


Nice to CU

Санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийн товч танилцуулга – 2023 оны 1-р хагас жил

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК
MSE: CUMN

- Компанийн тухай
- 2023 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд
- Дэлгүүрийн тэлэлт
- Технологи- Шийдэл
- Тогтвортой хөгжлийн зорилго
- Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт
- Үйл ажиллагаа, цар хүрээ
- Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт
- Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлт

- Монголын анхны конвениенс дэлгүүр “Сэнтрал Экспресс” нь 2015 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд 2018 онд дэлхийн конвениенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн шилдэг туршлага, нөү-хау бүхий БНСУ-ын 30 гаруй жилийн туршлагатай, CU брэндийн эзэмшигч BGF Retail компанитай мастер франчайзийн гэрээг байгуулж, худалдаа үйлчилгээний салбарыг нэг шатаар ахиулсан нь өдгөө иргэдийн амьдралын салшгүй хэсэг болж өргөжин тэлсээр байна.
- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь CU конвениенс дэлгүүрээрээ дамжуулан хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралд эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг хамгийн ойр байрлах ая тухтай орчинд 24 цагийн турш санал болгохыг зорин ажилладаг юм.



✓ CU хүнсний сүлжээ дэлгүүр



✓ Түгээлтийн төв



✓ Хүнсний үйлдвэр



✓ Оффис



Компанийн тухай Түүхэн амжилтууд



Сэнтрал Экспресс нэртэй Монголын хамгийн анхны конвинеенс сүлжээ дэлгүүрийн суурийг тавив.

2015 он



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК-ийг үүсгэн байгуулав.

2017 он



БНСУ-ийн BGF Retail компанийн мастер франчайз эрхийг Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК хүлээн авав.

Монгол улсын "Анхны ая тухтай" дэлгүүр MNS гэрчилгээ авав.

2018 он



CU брэнд 50 салбар дэлгүүртэй болов.

Нэг өдөрт үйлчлүүлэгчдийн тоо 30,000 -д хүрэв.

Монголын хамгийн анхны гар утасны апплейшнд суурилсан үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр CU апп-ийг нэвтрүүлэв.

2019 он



4,200 м² энгийн температурын горимтой түгээлтийн төвийг ашиглалтад оруулав.

Петровис ШТС-үүдэд салбар дэлгүүрүүд нээв.

Монголын ТОП-100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарав.

Монголын хамгийн хурдан 30 минутын дотор хүргүүлэх "CU Хүргэлтийн үйлчилгээ"-г нэвтрүүлэв.

CU салбар дэлгүүрийг франчайзийн эрхээр жижиг дунд бизнес эрхлэгчдэд эзэмшүүлж эхлэв.

Монголын хамгийн анхны 100 салбар дэлгүүртэй сүлжээ болов.

Монголын хамгийн анхны хүнсний аюулгүй байдлын олон улсын GMP, HACCP стандартыг хангасан хоолны үйлдвэрийг байгуулж, ашиглалтад оруулав.

2020 он



CU апп 320 мянган гишүүнтэй болов.

CU брэнд 127 салбар дэлгүүртэй болов.

CU брэнд НҮБ-ын хүүхдийн сантай хамтран "Байгальд ээлтэй Монгол гэр" төслийг хэрэгжүүлж эхлэв.

ЦЕГ-ын Хүүхэд хамгааллын хэлтэстэй хамтран "CU ЧАМД ТУСАЛТЯ" төслийг хэрэгжүүлж эхлэв.

Олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох ажлыг эхлүүлэв.

2021 он



CU ая тухтай дэлгүүрийн салбарууд 24 цаг ажиллаж эхлэв.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Circle K сүлжээ дэлгүүрийн 12 салбарыг худалдан авав.

Монголын ТОП 100 ААН-ийн 39-т эрэмблэгдэв.

CU 200 дах салбар дэлгүүрээ нээв.

Нэг өдрийн борлуулалт 1 тэрбум төгрөгт хүрэв.

CU конвинеенс дэлгүүр үйлчилгээний хүрээгээ тэлж Налайх дүүрэг болон Дархан-Уул аймагт шинэ салбараа нээв.

Экспресс Си Ви Эс ХК-ийн үнэт цаасны ангиллыг ахиулан II дугаар ангилалд бүртгэв.

БНСУ-ын нөү хау шингэсэн цогц мэдээллийн систем "GLOBAL IT SYSTEM"-ийг нэвтрүүлэх төслийг амжилттай хэрэгжүүлж нийт дэлгүүрийн хэмжээнд бүрэн гүйцэтгэж дуусав.

CU сүлжээ дэлгүүр 00:00-07:00 цагийн хооронд 18 хувиас өндөр спиртийн агууламжтай согтууруулах ундааг худалдаалахгүй байх шийдвэрийг гаргав.

2022 он

85,7 сая хүнд
үйлчилгээ үзүүлсэн

17,5 сая ширхэг
эрүүл, аюулгүй хоолыг
үйлдвэрлэн нийлүүлсэн

Улсын төсөвт

₮33,9 тэрбум
татвар, шимтгэл төлсөн



16,829 хүнийг
ажлын байраар хангасан

Дотоодын үйлдвэрлэгч,
бэлтгэн нийлүүлэгчдээс

₮596,9 тэрбум
худалдан авалт хийсэн

600 гаруй дотоодын ханган
нийлүүлэгчидтэй хамтран ажилласан

2023 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд



Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Монгол Улсын Засгийн газар, МҮХАҮТ хамтран эрэмбэлэн, өргөмжилдөг ТОП 100 ААН-ийн жагсаалтад өмнөх оноос 28 байраар урагшилж 11-т эрэмбэлэгдэн, худалдаа үйлчилгээний салбартаа **ТЭРГҮҮЛСЭН** амжилтыг үзүүллээ .

МОНГОЛ УЛСЫН ТОП 100 ААН 11 ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ САЛБАРТ ТЭРГҮҮН 1



2023 оны эхний хагас жилийн онцлох үйл явдлууд

GOOD WORKPLACE 2023 AWARDS

“Карьерын хөгжлийг дэмжигч шилдэг ажил олгогч”-оор шалгарлаа. Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь Карьер хөгжлийн системийг 2021 оны 9 сараас нэвтрүүлсэн бөгөөд карьер хөгжлийн систем нэвтэрсэн хугацаанд нийт 1676 ажилтанд карьерын төвшингээ ахиулан цалингаа нэмэгдүүлж, өсөн дэвших боломжийг олгосон байна.




“КАРЬЕРЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИГЧ
ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ”

FRIENDLY 300



- Монголын зах зээлд найрсаг, хурдтай ая тухтай дэлгүүрийн үйлчилгээг нэвтрүүлэх зорилготой нээгдсэн CU брэнд маш хурдацтай өсөж, борлуулалтаа гурав дахин, нийт ажлын байраа хоёр дахин тэлсэн амжилттай ажилласан CU сүлжээ дэлгүүр 300 дахь салбараа Хан-Уул дүүргийн Гэрлүг Виста хотхонд 2023 оны 3 сарын 7-ний өдөр нээлээ.



2023 оны эхний хагас жилд Улаанбаатар хотын хүн ам сийрэг суурьшсан бүс рүү түлхүү тэлэлт хийснээс гадна Эрдэнэт, Дархан, Зуунмод, Баянчандмань, Налайх, Баянгол зэрэг хот сууринд шинэ салбараа нээж орон нутаг, алслагдсан дүүргүүдийн шинэ зах зээлд амжилттай нэвтэрч чадлаа.

CU сүлжээ дэлгүүр нь нийт 326 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна

DAS/DPS хагас автоматжуулалтын системийг бүрэн нэвтрүүлэв.

- ✓ Захиалга бэлтгэгчийн бүтээмж 2 дахин нэмэгдсэн.
- ✓ Алдаатай захиалга бэлтгэх магадлал буурсан.
- ✓ Энэхүү систем нь шинэ ажилтан хурдан суралцаж, өндөр бүтээмж гаргах боломжтой болсон.



Хүйтэн хэлхээний агуулахад өргөтгөл хийгдэв.

- ✓ 446 дэлгүүрт өдөр бүр 2-3 удаа түгээлт хийх багтаамжтай болсон.
- ✓ Нэмэлтээр 4 ачих хаалга нэмэгдэж түгээлтийн машинд бүтээгдэхүүнийг ачих процесс хурдсав.
- ✓ Хөлдүү бүтээгдэхүүний агуулахын багтаамж нэмэгдсэн.



2023 оны эхний хагас жилд CU гар утасны аппликейшний шинэчлэгдсэн хувилбарыг нэвтрүүлсэн бөгөөд тус хувилбарын дараах 3 шинэ шийдлүүдийг онцолж байна.



Хэрэглэгчийн цаг завьг хэмнэх И-баримтын автомат бүртгэл



Голомт банкт хамтарсан 45 хоногийн хугацаатай хүүгүй зээлээр худалдан авалт хийх



Судалгаа бөглөн санал, хүсэлт өгөх, урамшуулал авах боломж

Тогтвортой хөгжлийн зорилго

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь НҮБ-н Тогтвортой хөгжлийн зорилгуудын хүрээнд байгаль орчин, нийгэм, эдийн засагтаа эерэг нөлөөллийг бий болгон, салбартаа манлайлан ажиллахыг зорин, өдөр тутмын үйл ажиллагаагаараа Тогтвортой хөгжлийн 17 зорилгын 11 зорилгод дараах байдлаар хувь нэмрээ оруулан ажиллаж байна.



ЯДУУРЛЫГ УСТГАХ

Уян хатан цагийн хуваарь бүхий ажлын байрыг бий болгож, орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжийг хөдөлмөрийн насанд хүрсэн иргэн бүрд нээлттэй санал болгон ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулан ажиллаж байна. Үүсгэн байгуулагдсан цагаасаа нийт 16,829 хүнийг ажлын байраар хангаж. 2023 оны эхний хагас жилд 2,069,927 хүн цагийн ажил бий болгосон ба нийт ажилтнуудын 70% нь цагийн ажилтан байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ

CU сүлжээ дэлгүүр нь үйлчлүүлэгчдийнхээ эрүүл мэндийг хамгаалах зорилгоор НАССР олон улсын чанар, хяналтын шаардлагыг хангасан үйлдвэрт бэлтгэсэн хоолыг өдөр бүр дэлгүүрүүдээрээ дамжуулан хэрэглэгчдийн гарт хүргэдэг.

Мөн 2023 оны 3 сард түгээлтийн машинуудад нэмэлтээр температур хянагч төхөөрөмжүүдийг суурилуулснаар эмзэг бүтээгдэхүүний дэлгүүрт очих хүртэлх температурын горимыг тээвэрлэлтийн явцад нарийн хянадаг болж хэрэглэгчдийн эрүүл мэндийг дэмжин ажиллаж байна.



ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

Хүйсийн эрх тэгш байдал, нийгмийн тэгш оролцоог хангах чиглэлд онцгой анхаарал хандуулан ажилладаг ба компанийн төв оффис, түгээлтийн төв, хоолны үйлдвэр болон 326 салбар дэлгүүрт 2900 орчим ажилтантайгаас 66,7%- ийг эмэгтэй ажилтнууд бүрдүүлж байна.

2023 онд жендерийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоог нэмэгдүүлэх зорилгын хүрээнд Капитрон Банк болон Зээлийн Батлан Даалтын Сантай хамтран бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгох хамтын ажиллагаагаа эхлүүллээ. Ингэснээр эмэгтэй бизнес эрхлэгчдэд уян хатан шалгууртай, шимтгэлгүй, бага хүүтэй зээлээр дэлхийн стандартад нийцсэн, шинэлэг, ая тухтай орчин бүхий CU салбар дэлгүүрийг өөрийн болгож, хувийн бизнестэй болох боломжийг олгож байгаа юм.



БАТАЛГААТ УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖААР ХАНГАХ

Ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийтийн талбайн цэвэр цэмцгэр байдал, эрүүл орчин бүрдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж байна. CU сүлжээ дэлгүүрүүдийн 91% нь чанарын шаардлага хангасан ариун цэврийн өрөө, гар угаах тосгуураар тоноглогдсон байдаг бөгөөд үйлчлүүлэгчдэдээ үнэ төлбөргүй үйлчилдэг.



ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР БА ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ

Хүнсний худалдаа төдийлөн байршдаггүй оффис, эмнэлэг, зам дагуух зэрэг байршлууд болон хүн амын суурьшлын бус шинэ байршлуудад салбаруудаа нээж хүний өдөр тутмын хэрэгцээг хангах үйлчилгээг үзүүлж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,9 тэрбум төгрөгийн татвар төлж, 2900 орчим ажилтай байж, нийт 5 жилийн хугацаанд 16,829 хүнийг ажлын байраар ханган ажиллажээ.

ИННОВАЦ БОЛОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Найдвартай хүнсний гинжин хэлхээг байгуулж 14,181,750 цэгийн түгээлтийг 432,000 болгон дэд бүтцийн хөгжүүлэлт хийв.

Агуулахын бараа ангилалт, ялгалтын DAS/DPS шийдлийг Монголд анх удаа нэвтрүүлж 99%-ийн оновчлолтой захиалгын системийг бий болгов. CU апп шинэчлэл хийн өдөр тутмын бараа бүтээгдэхүүнээ зээлээр худалдан авах, и-баримтын автомат бүртгэл, хэрэглэгчээс судалгаа аван боловсруулах шийдлүүдийг нэвтрүүлэв.

ТЭГШ БУС БАЙДЛЫГ БУУРУУЛАХ

Нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриас нь үл хамааран хүн бүрийг тэгш оролцох боломжоор ханган ажиллаж байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах, тэгш бус байдлыг бууруулах чиглэлд ажил олгогчид болон нийгэмд уриалан ажилладаг. Хөдөлмөрийн насны өрхийн гишүүн бүрийг амьдралынхаа хэв маяг, боломжит цагтаа тохируулан CU-д ажиллан, орлогын шинэ эх үүсвэртэй болох боломжоор хангаснаар орлогын тэгш бус байдлыг бууруулахад хувь нэмэр оруулж байна.

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ БАГАСГАХ

Кофены аяга болон таг нь 95% байгальд уусдаг материалтай. 2023 оны эхний хагас жилд нийт 201,362кг хаягдал байгаль орчныг бохирдуулахаас сэргийлсэн байна.



ЭЭЛТЭЙ ХОТ, ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ

Бусдыг хүндэтгэн мэндчилэх, харилцаа, үйлчилгээний соёлтой холбоотой сургалтыг тасралтгүй явуулж, хотын соёлд өнгө нэмсээр байна. Өдөр бүр 140,000 орчим үйлчлүүлэгчдэд ая тухтай үйлчилгээг хүргэж, цаг завьг нь хэмнэн үйлчилж, ICU төслийн хүрээнд CU сүлжээ дэлгүүр нь төөрсөн хүүхдийг хамгаалах, эцэг эх, асран хамгаалагчид нь аюулгүй хүлээлгэн өгч байна. Хүн амын суурьшлын төлөвлөлт, хот байгуулалтыг сайжруулах чиглэлд хотын алслагдсан дүүргүүд болон орон нутгаар 2023 онд эрчимтэй тэлэлт хийн ажиллаж байна.



ХАРИУЦЛАГАТАЙ ХЭРЭГЛЭЭГ ДЭМЖИХ

Тогтвортой байдалд чиглэсэн арга ажиллагааг компанийн бодлогын төвшинд авч үзэн, энэ талаарх мэдээллийг өөрсдийн Байгаль орчин, нийгэм, засаглалын тайландаа жил бүр тусган ажилладаг. Мөн аягаа авчран хямдралтай үнээр кофе худалдан авах зэрэг урамшууллыг зарлан, нийгэмдээ хариуцлагатай хэрэглээг дэмжихийг уриалж байна.



ЭНХ ТАЙВАН, ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛООХ

CU сүлжээ дэлгүүр нь 00:00-07:00 цагийн хооронд 18 хувиас өндөр спиртийн агууламжтай согтууруулах ундааг худалдахгүй байж гэмт хэргийн гаралтыг бууруулах, нийгмийн амар тайван, эрсдэлгүй орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулдаг ба архи согтууруулах ундааг худалдаалахад заавал иргэний үнэмлэх шалгаж, шалгуулж хэвших соёлыг нийгэмдээ үлгэрлэн уриалан ажиллаж байна.


Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт

Тэрбум төгрөг

	2022H1	2023H1	YoY%	YoY₮
Системийн борлуулалт (НӨАТ-тэй)	125.8	185.7	+47%	+59.9
Цэвэр орлого	111.2	167.2	+50%	+56.0
Нийт ашиг (алдагдал)*	0.6	-5.8	-866%	-6.4
Нийт ашгийн (алдагдал) хувь	0.5%	-3.5%	-600%	-4.0%
Цэвэр алдагдал	-7.1	-19.4	-173%	-12.3

*Цэвэр орлого болон нийт ашгийн зөрүү буюу борлуулалтын өртөгт дэлгүүрийн үйл ажиллагааны зардал багтсан болно.

Орлого, үр дүнгийн гол үзүүлэлт



	2022H1	2023H1	YoY%
Салбар дэлгүүрийн тоо	228	325	+42%
Үйлчлүүлэгчдийн тоо	14.8 сая+	20.0 сая+	+35%
Ажилтны тоо	2,800+	2,900+	-
Вендорын тоо	520+	500+	-4%
Хувьцаа эзэмшигчдийн тоо	9,638	10,022*	+4%

*2023/05/31-ний байдлаар

Санхүүгийн байдлын тайлангийн гол үзүүлэлт

Хөрөнгө (гол үзүүлэлтүүд)	2022Н1	2023Н1	Өөрчл өлт₮
Эргэлтийн хөрөнгө	38.4	37.7	-0.7
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	3.9	2.4	-1.5
Бараа материал	23.4	27.9	+4.5
Эргэлтийн бус хөрөнгө	112.5	140	+27.5
Ашиглах эрхтэй хөрөнгө / Түрээсийн авлага*	38.4	56.0	+17.6
Нийт хөрөнгө	150.8	177.7	+26.9

Тэрбум төгрөг.

Өр төлбөр, эздийн өмч (гол үзүүлэлтүүд)	2022Н1	2023Н1	Өөрчл өлт₮
Нийт өр төлбөр	102.4	178.6	+76.2
Эргэлтийн өр төлбөр	46.9	82.0	+35.1
Худалдааны болон бусад өглөг	39.2	42.9	+3.7
Богино хугацаат зээл	2.0	6.4	+2.2
Эргэлтийн бус өр төлбөр	55.5	96.6	+41.1
Урт хугацаат зээл	14.4	36.4	+23.0
Урт хугацаат түрээсийн өглөг*	41.0	59.9	+18.9
Нийт эздийн өмч	48.5	-0.9	-49.4
Нийт өр ба эздийн өмч	150.8	177.7	+26.9

*СТОУС16-тай холбоотойгоор бүртгэгддэг дансууд болно.

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК

- 25.0 (35.0*) тэрбум төгрөг - Хөрөнгө оруулалтын зээл
- 3.0 тэрбум вон - Хөрөнгө оруулалтын зээл
- 3.0 (5.0*) тэрбум төгрөг - Зээлийн шугам

Сэнтрал Фүүдс ХХК

- 2.3 тэрбум төгрөгийн зээлийн дахин санхүүжилт
- 4.6 тэрбум төгрөгийн зээлийн хуваарийн өөрчлөлт


*Тайлант үеийн дараах өссөн дүн

Мөнгөн гүйлгээний тайлангийн гол үзүүлэлтүүд(тохируулсан)



	2023H1	2022H1	YoY%
Үйл ажиллагааны МГ	-5.2	+5.9	-11.1
Хөрөнгө оруулалтын МГ	-9.8	-14.2	+4.4
Чөлөөт мөнгөн урсгал	-15.0	-8.3	-6.7
Санхүүгийн МГ	+13.1	-6.3	+19.4
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	2.4	3.9	-1.5

Хувьцааны үнийн хөдөлгөөн



АНХААРЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

ТАВТАЙ МОРИЛ

CU

CENTRAL
express